



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 33

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Ахмадын хороонд шаардлагатай нийт 5,757,780 /таван сая долоон зуун тавин долоон мянга долоон зуун ная/ төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг балансын үнээр нь бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Аймгийн Ахмадын хорооны дарга Ц.Сугирт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

480219072

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын
02 өдрийн 33 тогтоолын 1 хавсралт



Ахмадын хорооны
худалдан авах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Компьютер /зөөврийн/	1	1,959,990	1,959,990
2	Принтер /олон үйлдэлт/	1	569,900	569,900
3	Дэлгэц самбар	1	449,990	449,990
4	Проектор	1	1,259,900	1,259,900
5	Видео камер	1	998,000	998,000
6	Өсгөгч	1	460,000	460,000
7	Микрофон	2	30,000	60,000
	Нийт дүн			5,757,780 /таван сая долоон зуун тавин долоон мянга долоон зуун ная/